



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 19 өдөр

Дугаар 277

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухааны академийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 80,991,928.00 (наян сая есөн зуун ерэн нэгэн мянга есөн зуун хорин найман) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Шинжлэх ухааны академийн Физик, технологийн хүрээлэнд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Ням-Очир, Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгч Д.Рэгдэл, Шинжлэх ухааны академийн Физик, технологийн хүрээлэнгийн захирал П.Алтанцог нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002005



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн
 2... дугаар тогтоолын хавсралт

Шинжлэх ухааны академийн балансаас Шинжлэх ухааны академийн Физик, технологийн хүрээлэнгийн
 балансад шилжүүлэх эд хөрөнгийн жагсаалт

| Д/д | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад орсон он | Балансын | | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэгдэл өртөг |
|-----|-----------------|-------------|------------|------------------------|---|----------------------|--------------------------|----------------|
| | | | | | нэг бүрийн үнэ | нийт үнэ | | |
| | | | | | (төгрөг) | | | |
| 1 | Хашаа | Ш | 1 | 2011 | 80,991,928.00 | 80,991,928.00 | 80,991,928.00 | - |
| | Нийт дүн | | 1 | | 80,991,928.00 | 80,991,928.00 | 80,991,928.00 | 0 |
| | | | | | (наян сая есөн зуун ерэн нэгэн мянга есөн зуун хорин найман) | | | |